

## **PETROLEUM POTENTIAL OF MONGOLIA AND GOVERNMENT POLICY ON PETROLEUM EXPLORATION**

On behalf of Petroleum Authority of Mongolia, I would like to express today's pleasure to all participants of this event.

I will present "Petroleum Potential of Mongolia and Government Policy on Petroleum Exploration". My speech is divided into three sections:

1. The Petroleum Potential
  - Brief History
2. Government Policy on Petroleum Exploration
  - Favorable Legal Environment
3. The Current Operation

### **1. Petroleum Potential**

#### ***- Brief History***

Petroleum exploration in Mongolia began with the classification of Mesozoic and Tertiary sediments and the discovery of outcrop of oil-shale related to petroleum genesis during the geological research by American geologists H. Berkley and C. Morris in 1922-1923 in the Gobi region of the country. The existence of oil in Mongolia was presumed by American geologist D. Tenner in 1931, and the Zuunbayan oilfield in East Gobi was discovered by Mongolian geologist J. Dugersuren and Soviet geologist Yu.S. Jelubovsky in 1940.

Between 1947 and 1963, two small oilfields and 80 buried structures with possible oil potential, were discovered during the petroleum exploration by former Soviet geologists in the southern, southeastern and eastern parts of the country.

In 1947, "Mongolnefti" trust was established and an oil refinery with a processing capacity of about 0.4 million barrels per year was built in Zuunbayan in 1950. Between 1950 and 1969, over 4 million barrels of oil were produced from the Zuunbayan oilfield and a total of 7 million barrels of oil (including lighter oil imported from Russia to be mixed with Zuunbayan oil) were processed at the refinery, which supplied more than 20% of the country's fuel and lubricants demand at that period. However, due to several factors such as well pressure decrease, the fire accident that destroyed the refinery, and discoveries of giant oil fields in western Siberia, Russia, petroleum operations in Mongolia was ceased in 1969.

In 1991, the Petroleum Law of Mongolia was ratified by the Parliament and the Regulation for implementing the Petroleum Law was adopted by the Government of Mongolia. The Law established a legal foundation for new development of petroleum exploration in Mongolia. The Petroleum Law of Mongolia was ranked to be within the Top 10 favorable petroleum laws in the world, according to the Van Meurs rates in 1995.

The Petroleum Authority of Mongolia (PAM) is a Government agency, authorized by the Government of Mongolia to enter into contracts on the matters of oil and gas exploration, development, production and supply of petroleum products in Mongolia, and to exercise supervision and assistance towards the implementation of such contracts.

- *Mongolian Sedimentary Basin*

**Mongolia's sedimentary basins, prospects for petroleum, were divided into 25 exploration blocks (with a total area of over 614,000 square kilometers) for which Mongolia carried out two international exploration promotion biddings.**

2. Government Policy

The Government policy in the petroleum sector is aimed at developing exploration of the petroleum potential of Mongolia, increasing production and fully supplying oil products from a domestic oil refining industry based on domestic resources to the country's needs through mutually beneficial cooperation with potential international oil companies.

The Government of Mongolia approved 2 programs which are "Guidelines for Petroleum Sector until 2010" and "Liquefied Gas". In order to implement these programs, the government policy is aimed at intensifying petroleum exploration, development and production operations in Mongolia and developing natural gas and coalbed methane gas exploration, development and production.

- *Favorable Legal Environment*

The main form of petroleum exploration contracts is considered to be Production Sharing Contracts (PSC). A contractor shall submit an application to the PAM, an authorized organization of Mongolian Government, and PAM shall sign in PSC with the contractor in basis of recommendation of the National Security Council and permission of the Mongolian Government.

In accordance with the Petroleum Law of Mongolia the term of exploration period might be up to five (5) years and may extend two (2) times, by two (2) year extension terms, each. According to the Resolution of the Government of Mongolia of 2004, investors have new possibility an additional agreement on an extension of the exploration terms for 5 years with regard to the Contract Areas. The term of Development Operations might be up to twenty (20) years and may extend for two (2) times, by not more than five (5) year extension terms, each.

In order to develop a favorable investment climate for the industry and to reduce investors' risks,

- all materials and equipment necessary to conduct petroleum operations, imported by contractors, are exempt from all **customs taxes, value added taxes and excise taxes.**
- **The earnings** of contractors from their share of petroleum are also exempt from **income taxes.**

In addition, according to the Foreign Investment Law of Mongolia, at the request of the investor intending to undertake a project of not less than **US\$2 million** and **US\$10 million** in

Mongolia, the Cabinet Member responsible for taxation policy may sign either one of two kinds of **Stability Agreement**, depending on amount of investment, with the investor as a legal guarantee for a stable fiscal environment for 10 to 15 years. This protects the contractor from any changes of taxation policy.

### **3. Current Operations**

**At present, Daqing Oilfield, China is, in Contract Areas XIX, XXI and XXII, Tamtsag basin, and Dongsheng, China is, in parts of Contract Areas XIII and XIV, conducting petroleum exploration activities in basis of a Production Sharing Contract.**

End of last year, the Production Sharing Contract on coal bed methane gas operations in the exploration area of Nemegt-VI and Borzon-VII signed by StormCat Co., Ltd, Canada. Its exploration activities have begun this year.

Since 1993, 13.8 thousand straight kilometers of 2D seismic and 1791 square kilometers of 3D seismic were acquired, 100 petroleum exploration wells were drilled. 210.3 million USD has being invested in petroleum exploration operations.

By the end of 2005, Petrochina Daqing Tamtsag Mongolia, LLC and Dongsheng Jinggong Petroleum Mongolia produced totally 1.2 million barrels of the crude oil from their contract areas and 1.1 million barrels were exported by railway and trucks to China.

In March 23, 2004, a Joint Exploration Agreement (JEA) was signed between the MRPAM and Dongsheng Jinggong Petroleum Mongolia, China on exploration areas Block II and III for research activities on petroleum potentials. According to this Agreement, the company had spent USD 262,000.00 for this project.

Thank you for your kind attention.

Detailed information is available at our website: <http://www.mrpam.gov.mn>

## МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЗАСГИЙН ГАЗРААС БАРИМТЛАЖ БУЙ БОДЛОГО

АМГТХЭГ-ын нэрийн өмнөөс энэ арга хэмжээнд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлж байна.

Миний өнөөдрийн илтгэлийн сэдэв “Монгол улсын газрын тосны салбарын өнөөгийн байдал, Засгийн газраас баримтлаж буй бодлого”. Энэ илтгэл үндсэн 3 хэсгээс бүрдэж байгаа юм. **Нэгдүгээрт**, Газрын тосны салбарын товч түүхийн тухай **хоёрдугаарт**, газрын тосны салбарт Монгол улсын Засгийн газраас баримтлаж буй бодлого буюу хууль, эрхзүйн таатай орчин, **гуравдугаарт**, Газрын тосны хайгуул олборлолтын өнөөгийн байдал.

### **1. Товч түүх**

1922-1923 онуудад Америкийн геологич Н. Берклэй, С. Моррис нар геологийн судалгааны ажлаараа Мезозойн болон Гуравдагчийн хурдсуудын ангилал хийж, мөн газрын тосны гарал үүсэлтэй холбоотой шатдаг занарын илэрц говь нутагт олж тогтоосноор Монголын газрын тосны судалгаа эхэлсэн түүхтэй. Харин газрын тос агуулагдаж байгааг Америкийн геологич Д. Теннер 1931 онд тогтоосон бөгөөд улмаар Монголын геологич Ж. Дүгэрсүрэн, Зөвлөлтийн геологич Ю. С. Желубовский нар Дорноговийн сав газарт Зүүнбаянгийн газрын тосны ордыг 1940 онд нээсэн.

1947-1963 онуудад Зөвлөлтийн газрын тосны геологичид Монгол орны өмнөд, зүүн-өмнөд, зүүн нутгуудаар газрын тосны эрэл хайгуулын ажил явуулснаар Зүүнбаянгийн сав газарт бага хэмжээний 2 орд, газрын тос агуулж болох 80 орчим далд бүтэц илрүүлсэн.

1947 онд “Монголнефть” трест байгуулагдаж жилд 55 мянга орчим тонн (400 мянган баррель) газрын тос боловсруулах хүчин чадалтай боловсруулах үйлдвэр Зүүнбаянд ашиглалтанд оруулсан бөгөөд энэ үйлдвэр нь 1950-1969 онуудад Зүүнбаянгийн ордоос олборлосон 538,7 мянган тонн (4 сая гаруй баррель) газрын тосыг ЗХУ-аас импортоор оруулж ирсэн шингэн газрын тостой хольж нийтдээ 956,7 мянган тонн (7 сая гаруй баррель) газрын тос боловсруулж тухайн үеийн шатах, тослох материалын улсын хэрэгцээний 20%-ийг хангаж байсан. Гэвч цооногийн даралт буурсан, боловсруулах үйлдвэрт гал гарч шатсан, баруун Сибирьт газрын тосны том ордууд нээгдсэн зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан уг боловсруулах үйлдвэр хаагдаж, Монголд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа 1969 онд зогссон.

1991 онд Монгол Улсын “Газрын тосны тухай” хууль, Засгийн газраас уг хуулийг хэрэгжүүлэх журмыг тус тус батлан гаргасан нь Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны хайгуул хийх, газрын тос олборлох, энэ салбарт гадаад улс орон, пүүс компанитай хамтран ажиллах эрх зүйн үндсийг тавьж өгсөн билээ.

Газрын тосны геологичдийн Америкийн нийгэмлэгийн “Эксплорер” сэтгүүлийн 1995 оны 8-р сарын дугаарт Монгол Улсын “Газрын тосны тухай” хууль нь “Педро ван Майерс” компанийн үнэлгээгээр дэлхийн шилдэг 10 хуулиудын нэгээр шалгарсан.

Монгол Улсын Газрын тосны хуулийн дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар хариуцдаг.

**- Сав газрууд**

Монголд газрын тос байж болох магадлал бүхий 614,000 мянган хавтгай дөрвөлжин км. нутаг дэвсгэрийг хамарсан 25 талбай ялгаж олон улсын тендер зарласан юм.

**2. Газрын тосны салбарт Засгийн газраас баримталж буй бодлого**

Монгол Улсын Засгийн газрын бодлого нь газрын тосны нөөц баялгийг хайж, олборлох, дотоодын түүхий эдэд түшиглэсэн боловсруулах үйлдвэр барьж байгуулахад чиглэгдэж байна.

**- Хууль, эрхзүйн таатай орчин**

Газрын тосны хайгуул, олборлолт явуулах хамтын ажиллагааны үндсэн нөхцөл нь Бүтээгдэхүүн хуваах гэрээ юм. Г эрээлэгч газрын тостой холбоотой үйл ажиллагаа явуулах өргөдлөө АМГТХЭГ-т гаргана. АМГТХЭГ нь Засгийн газрын зөвшөөрөл, Үнд эсний аюулгүй байдлын зөвлөмжийн дагуу Гэрээлэгчтэй гэрээ байгуулна.

Газрын тосны тухай хуулийн дагуу эрэл, хайгуулын ажил явуулах хугацааг 5 жил хүртэл байх ба энэ хугацааг 2 удаа тус бүр 2 жилээр сунгаж болдог. Саяхан батлагдсан 2003 оны УИХ-ын хууль, 2004 оны Засгийн газрын тогтоолын дагуу хөрөнгө оруулагч нар гэрээт талбайн хайгуулын хугацааг дахин 5 жилээр сунгах нэмэлт хэлэлцээр байгуулах шинэ боломжтой болсон. Олборлолтын хугацаа 20 жил хүртэл байх бөгөөд 2 удаа 5-аас дээшгүй жил ээр сунгах боломжтой юм.

Тус салбарт хөрөнгө оруулах таатай орчин бүрдүүлэх, хөрөнгө оруулагчдын эрсдэлийг багасгах зорилгоор:

- газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан оруулж ирэх тоног төхөөрөмж, эд материалыг **гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, онцгой татвараас**
- гэрээлэгчид ногдох газрын тосноос олох ашгийг **орлогын албан татвараас** тус тус чөлөөлж байгаа билээ.

Мөн Монгол Улсын "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай" хуулинд зааснаар Монголд 2 сая ам.доллараас дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаагаа явуулах орчныг тогтвортой байлгах эрх зүйн баталгаа болгож **Тогтвортой байдлын гэрээ** байгуулж болох бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчийг аливаа татварын өөрчлөлтөөс 10-15 жилд хамгаална гэсэн үг юм.

**3. Газрын тосны хайгуул олборлолтын өнөөгийн байдал**

Одоогийн байдлаар БНХАУ-ын Дачин Тамсаг Монгол компани Дорнод аймгийн Тамсагийн сав газрын XIX, XXI, XXII талбайд, БНХАУ-ын "Доншен Жингун

Петролеум Групп" компани Дорноговийн сав газрын XIII, XIV (БХГ-97) талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагааг Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний зарчмаар гүйцэтгэж байна. 2006 онд монголын үнд эсний компани болох "ТООИТЭД" анх удаа АМГТХЭГ-тай Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан.

1993 оноос эхлэн газрын тосны хайгуулын 2 хэмжээст чичирхийллийн судалгаа 13.8 тууш км, 3 хэмжээст чичирхийллийн судалгаа 100 хав. дөр. км нутагт хийж гүйцэтгэсэн ба хайгуулын нийт 100 цооног өрөмдөөд байна. Газрын тосны хайгуулын ажилд нийт 210,3 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийгдээд байна.

Одоогийн байдлаар манай улсад хайгуул, олборлолтын ажил гүйцэтгэж байгаа БНХАУ-ын "Дачин Тамсаг Монгол" ХХК болон "Доншень" компаниуд Тамсаг, Дорноговийн сав газраас нийт 1.2 сая баррель газрын тос олборлож, 1,1 сая баррель газрын тосыг БНХАУ-руу автомашин болон төмөр замаар экспортлоод байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.